# Mongolian language for foreigners – Week 8
# Lecture №8

## Сэдэв: Монголчуудын дуу, хөгжим
## Topic: Mongolian song, music

**Сонсох, ярих, унших, бичих чадварыг дээшлүүлэх**

**listening, speaking, reading, writing**

**Mongolian National University Arts And Culture**
**Professor, Basbish.S**

## Хичээлийн агуулга - Lecture content

1. Өмнөх хичээлийн бататгал- Reviewing pervious learning
2. Монголчуудын дуу, хөгжим – Mongolian song and music
3. Шинэ үг хэллэгүүд- New words
4. Дасгал ажлууд- Exercises
5. Гэрийн даалгавар - Homework

**Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар**
**Reviewing pervious learning and homework**

**Мэдлэг шалгах тест - Test**

1. **Монголчууд өнгө бүрийг бэлгэдэлт утгатай гэж үздэг бөгөөд ................... ....................өнгийг сонгохын тулд бэлгэдлийг нь харгалздаг.**

   А. Эд зүйлийн    Б. Хоол хүнсний    В. Байгаль дэлхийн    г. Цаг агаарын

2. **Монголчууд эхийн цагаан сүүг хамгийн ..................... .................зүйл гэж бэлгэшээн дээдэлдэг бөгөөд цагаан өнгөөр сүүг төлөөлүүлэн, өнгө, өнгийн дундаас хамгийн ихээр эрхэмлэн дээдэлдэг.**

   А. Амттай, шимтэй    б. Ариун нандин    в. Тансаг сайхан    г. Өтгөн тослог

3. **Хөх өнгийг мөнх хөх ................өнгө гэж бэлгэшээн дээдэлж, энэ өнгийг хүндлэлийн дээд гэж үздэг.**

   А. Далайн    б. Голын    в. Талын    г. Тэнгэрийн

4. **Хөх цэнхэр өнгө нь мөн ................ёсыг илэрхийлдэг тул хөх, цэнхэр өнгийн хадгийг ихэвчлэн ах дүүсдээ барьж, мэнд мэдэн золгодог.**

   А. Эелдэг    б. Үнэнч    в. Найрсаг    г. Зочломтгой

5. **Улаан өнгийг .................. ...................өнгө, өөдлөн дэвжих, ялан дийлэхийн бэлгэ тэмдэг гэж бэлгэшээдэг.**

   А. Гал голомтны    б. Бурхан тахилын    в. Хоол хүнсний    г. Чимэг зүүлтний

(Мөнхцэцэг,Г., Орхон,Б, 2021, хууд. 138)

## Мэдлэг шалгах тест - Test

6. **Ногоон өнгө нь .................. .................., үржил хөгжлийг бэлгэдсэн өнгө бөгөөд санаа сэтгэлийн амар амгалан байдлыг илтгэнэ.**

   А. Газар дэлхий  б. Нар сар  в. Гараг эрхэс  г. Тэнгэр огторгуй

7. **Ногоон хадгийг ................. .....................зан үйлд хэрэглэнэ.**

   А. Тайлга тахилгын  б. Бурханд мөргөх  в. Ахмадуудтай золгох  г. Багш шавийн

8. **Шар өнгө бол амьдралыг тэтгэгч алтан шар ................өнгө юм.**

   А. Цэцгийн  б. Сарны  в. Нарны  г. Алтны

9. **Монголчууд шар өнгийг мөн эрдэм оюуны өнгө гэж үздэг бөгөөд шар өнгийн хадгийг................барьдаг.**

   А. Өвөөдөө  б. Эмээдээ  в. Даргадаа  г. Багшдаа

10. **Монголчууд хар өнгийг дийлдэж давагдашгүй ......................... .........................бэлгэдэл хэмээн үздэг.**

    А. Оюун ухааны  б. Хөгжиж цэцэглэхийн  в. Муу санааны  г. Сүр хүчний

(Мөнхцэцэг,Г., Орхон,Б, 2021, хууд. 138)

**Дасгал 1. Асуултыг уншаарай. - Read the questions.**

1. Монголчуудын хамгийн их эрхэмлэдэг хөгжмийн зэмсэг, дууны төрөл юу вэ?
2. Морин хуурыг яагаад морин хуур гэж нэрлэсэн бэ?
3. Уртын дууг яагаад уртын дуу гэж нэрлэсэн бэ?

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 106)

# Монголчуудын дуу, хөгжим
# Mongolian song, music

***Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.***
***Memorize the new vocabularies and understand the meaning***

1. Айзам – rhytm
2. Гарал үүсэл – origin
3. Гэрийн жавар үргээх – to expel energy
4. Зан үйл – ritual
5. Икэл –West Mongolian fiddle
6. Ёслол хүндэтгэлийн – ceremonial
7. Морин хуур – horse headed fiddle
8. Нум – bow
9. Нэвтрүүлэх – to broadcest
10. Сунжруулах – to drawl
11. Сүр хүч – might
12. Туйл хайлах – to intone an epic
13. Уртын дуу – drawling song
14. Цог хийморь – vivacity
15. Чавхдас – string

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 110)

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.***
***Exercise 2. Listen and fill the missing words***

***Нөхөх үгс - Choose from following words: морин хуур, ёслолын, икэл, эзэнт гүрнийг, арав орчим, үлгэр домог, 6000, жавар, хятад, нумаар***

## Монголчуудын уламжлалт дуу, хөгжим

Монголчуудын дуу хөгжим, найр наадмыг 1)________ ________, уртын дуугүйгээр төсөөлөхийн аргагүй юм. Эдгээр нь Монголчуудын амьдралын хэв маяг, байгаль дэлхийгээ дээдлэн шүтэх үзэлтэй холбоотой зохиогдсон.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 106)

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.***
***Exercise 2. Listen and fill the missing words***

***Нөхөх үгс - Choose from following words: морин хуур, ёслолын, икэл, эзэнт гүрнийг, арав орчим, үлгэр домог, 6000, жавар, хятад, нумаар***

**Морин хуур:** Энэ нь морин толгойтой, хос чавхдастай хөгжмийн зэмсэг. Морин хуурын гарал үүслийн талаарх Монголчуудын үзлийг хоёр ангилж болно. Монголын ард түмэн морин хуурын үүслийн талаар 2)_______ ______ хэлэлцсээр ирсэн.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 106)

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.***
***Exercise 2. Listen and fill the missing words***

***Нөхөх үгс - Choose from following words: морин хуур, ёслолын, икэл, эзэнт гүрнийг, арав орчим, үлгэр домог, 6000, жавар, хятад, нумаар***

Жишээлбэл “Хөхөө Намжилын домог”, “Аргасун хуурчийн домог”, “Жонон харын домог” гэх мэт. Эдгээр домгийн гол санаа нь хүн, морь хоёрын харилцаа, Монголчуудын морио эрхэмлэн дээдлэх, хайрлах сэтгэлгээнээс морин хуур хөгжмийн зэмсэг үүссэн тухай өгүүлдэг.



(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 106)

Өглөө.мн. (2015, June 9). Морин хуур үүссэн домог [Photograph]. https://www.ugluu.mn/129471.html

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.***
***Exercise 2. Listen and fill the missing words***

***Нөхөх үгс - Choose from following words: морин хуур, ёслолын, икэл, эзэнт гүрнийг, арав орчим, үлгэр домог, 6000, жавар, хятад, нумаар***

Харин хөгжим судлаачид морин хуур нь баруун Монголчуудын 3) "_______" хэмээх хөгжмийн зэмсгээс гаралтай бөгөөд сүүлд морин толгой дүрслэн урлаж, морин хуур хөгжим үүссэн гэж үздэг. Эрт үед модон хүрээг ямаа, ботгоны арьсаар бүрж, адууны сүүлний хялгасаар чавхдасыг нь хийдэг байв. Энэ хөгжмийн зэмсгийг адууны хялгасаар хийсэн 4) ________ хөрөөдөн тоглодог байжээ.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 106)

# Монголчуудын дуу, хөгжим
# Mongolian song, music






Munkhzaya, E. (2019, July 15). *Morin khuur structure* [Photograph]. Wikipedia.\

https://mn.wikipedia.org/w/index.php?title=%D0%9C%D0%BE%D1%80%D0%B8%D0%BD_%D1%85%D1%83%D1%83%D1%80&oldid=729109.#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:%D0%9C%D0%BE%D1%80%D0%B8%D0%BD_%D1%85%D1%83%D1%83%D1%80%D1%8B%D0%BD_%D0%B1%D2%AF%D1%82%D1%8D%D1%86.png

Johanna, K. (2007, July 23). *Икил* [Photograph]. Wikipedia.

https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D1%80%D0%B8%D0%BD_%D1%85%D1%83%D1%83%D1%80#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Igil_made_by_Oktober_Saya_side_view.gif

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.***
***Exercise 2. Listen and fill the missing words***

***Нөхөх үгс - Choose from following words: морин хуур, ёслолын, икэл, эзэнт гүрнийг, арав орчим, үлгэр домог, 6000, жавар, хятад, нумаар***

Морин хуур нь цар багтаамж ихтэй, дуу авиа илэрхийлэх чадвар сайтай хөгжмийн зэмсэг юм. Тийм учраас үүссэн цагаасаа эхлэн Монголчуудын дуу, хуур, бүжиг наадамд голлох хөгжмийн зэмсэг байсаар өнөөг хүрчээ. Монголын 5)_______ _______ байгуулсан эзэн Чингис хааны үед төрийн ёслол, хүндэтгэл найр цэнгээнийг морин хуур хөгжмөөр эхлүүлдэг байжээ.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 106)

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.***
***Exercise 2. Listen and fill the missing words***

***Нөхөх үгс - Choose from following words: морин хуур, ёслолын, икэл, эзэнт гүрнийг, арав орчим, үлгэр домог, 6000, жавар, хятад, нумаар***

Морин хуур нь монгол угсаатны соёл, зан заншлын уламжлалыг агуулсан хөгжмийн зэмсэг. Баяр наадам, хурим найр, ёслол хүндэтгэл, мал аж ахуйн холбогдолтой олон зан үйлд морин хуур тоглодог. Мөн ерөөл магтаал хэлэх, үлгэр тууль хайлахад ч морин хуур чухал үүрэгтэй. Монголчууд морин хуурыг гэрийнхээ 6)_______ хамгийн хүндтэй байранд тавьдаг.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 107)

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.***
***Exercise 2. Listen and fill the missing words***

***Нөхөх үгс - Choose from following words: морин хуур, ёслолын, икэл, эзэнт гүрнийг, арав орчим, үлгэр домог, 6000, жавар, хятад, нумаар***

Монголчуудын уламжлалт цагаан сарын баяраар айл өрх бүр жилдээ сайн явах, өвчин зовлон, хэрүүл тэмцэлгүй байхын бэлгэдэл болгон “Гэрийн жавар үргээж” морин хуураар ая өргөдөг заншилтай. Энэ уламжлалыг даган, жил бүрийн цагаан сараар Монгол улсын сүр хүч, айл өрх бүрийн түвшин жаргал, хүн бүрийн цог хийморийг бэлэгдэж, Төрийн 7)_______ өргөөнд “Төрийн их хан хуур”-ыг эгшиглүүлж, морин хуурын хүндэтгэлийн тоглолтыг орон даяар телевиз, радиогоор нэвтрүүлдэг.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 107)

# Монголчуудын дуу, хөгжим
# Mongolian song, music

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.***
***Exercise 2. Listen and fill the missing words***

***Нөхөх үгс - Choose from following words: морин хуур, ёслолын, икэл, эзэнт гүрнийг, арав орчим, үлгэр домог, 6000, жавар, хятад, нумаар***

2003 онд ЮНЕСКО Монголын ***"Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг"***-ийг “Хүн төрөлхтний аман болон утга соёлын шилдэг дээж”-ээр тунхаглаж, 2008 онд хүн төрөлхтний Соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад бүртгүүлсэн.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 107)


UNESCO
United Nations Educational, Scientific and Cultural Organization
Intangible Cultural Heritage
Convention for the Safeguarding of the Intangible Cultural Heritage

The Intergovernmental Committee for the Safeguarding of the Intangible Cultural Heritage has incorporated

*The traditional music of the Morin Khuur*

in the Representative List of the Intangible Cultural Heritage of Humanity upon the proposal of Mongolia

*Incorporation in this List contributes to ensuring better visibility of the intangible cultural heritage and awareness of its significance, and to encouraging dialogue which respects cultural diversity*

Date
*4 November 2008*

Director-General of UNESCO

Морин хуур [Photograph]. (2018). orkhonvalley.gov.mn. https://orkhonvalley.gov.mn/Ich/1

## “Хү” рок хамтлаг



Хулан, Э. (2020, October 20). Монголын металл хамтлаг [Photograph].
https://sonin.mn/news/enews/115482

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.***
***Exercise 2. Listen and fill the missing words***

***Нөхөх үгс - Choose from following words: морин хуур, ёслолын, икэл, эзэнт гүрнийг, арав орчим, үлгэр домог, 6000, жавар, хятад, нумаар***

**Уртын дуу:** 2000-аад жилийн өмнө Монгол нутагт хүчирхэгжсэн Хүннү гүрний хаан Модун Шаньютай холбоотой уртын дуу үүссэн тухай домог 8) ________ сурвалжид бичигдсэн байдаг. Энэ нь уртын дууны хамгийн эртний баримт юм.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 107)



Mendee. (2011, December 3). *Norovbanzad* [Photograph]. Wikipedia.

https://mn.wikipedia.org/w/index.php?title=%D0%9D%D0%B0%D0%BC%D0%B6%D0%B8%D0%BB%D1%8B%D0%BD_%D0%9D%D0%BE%D1%80%D0%BE%D0%B2%D0%B1%D0%B0%D0%BD%D0%B7%D0%B0%D0%B4&oldid=685024.#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Norovbanzad.jpg

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.***
***Exercise 2. Listen and fill the missing words***

***Нөхөх үгс - Choose from following words: морин хуур, ёслолын, икэл, эзэнт гүрнийг, арав орчим, үлгэр домог, 6000, жавар, хятад, нумаар***

Уртын дуу нь ард түмний амьдрал дундаас урган гарсан утга агуулгатай, зохиогч байдаггүй. Олон улсын тайлбар тольд “Монголын уламжлалт хөгжмийн урлагийн үндсэн элемент” хэмээн тодорхойлжээ.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 107)



Бадрал, С. (2016, September 12). Уртын дуучид [Photograph]. https://ikon.mn/n/tsw

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.***
***Exercise 2. Listen and fill the missing words***

***Нөхөх үгс - Choose from following words: морин хуур, ёслолын, икэл, эзэнт гүрнийг, арав орчим, үлгэр домог, 6000, жавар, хятад, нумаар***

Мөн “Дууны хэмжээ уртаас бус, шүлгийн үгийн үе бүрийг нугалаа айзам гарган сунжруулж, уртаар шуранхайлан дуулдаг онцлогоос нь үүдэн уртын дуу гэж нэрлэдэг. Энэ онцлогоос шалтгаалан зарим тохиолдолд дөрвөн минут үргэлжлэх дуу 9) ________ ________ үгтэй байх нь ч бий.” хэмээн тэмдэглэжээ.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 107)

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.***
***Exercise 2. Listen and fill the missing words***

***Нөхөх үгс - Choose from following words: морин хуур, ёслолын, икэл, эзэнт гүрнийг, арав орчим, үлгэр домог, 6000, жавар, хятад, нумаар***

Утга агуулгын хувьд харилцан адилгүй бөгөөд гүн ухаан, эцэг, эхийн ачлал, шашин, хайр дурлал, баяр ёслолын сэдэвтэй байдаг. Морь болон бэлгэдлийн утгатай үгс олон давтагддаг нь монгол үндэстний аж байдлын онцлогтой шууд холбоотой. Судлаачид 10) ________ гаруй уртын дуу байдгаас 60 орчим дуу байнга дуулагдаж байна гэж үздэг.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 107)

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.***
***Exercise 2. Listen and fill the missing words***

***Нөхөх үгс - Choose from following words: морин хуур, ёслолын, икэл, эзэнт гүрнийг, арав орчим, үлгэр домог, 6000, жавар, хятад, нумаар***

Монголын уртын дууны гайхамшигийг үнэлэн 2003 онд ЮНЕСКО “Хүн төрөлхтний аман ба биет бус өвийн шилдэг дээж”-д тунхаглаж, 2008 онд Соёлын биет бус өвийн “Хүн төрөлхтний төлөөний жагсаалт”-д бүртгэсэн.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 107)


UNESCO
United Nations Educational, Scientific and Cultural Organization
Intangible Cultural Heritage

Convention for the Safeguarding of the Intangible Cultural Heritage

The Intergovernmental Committee for the Safeguarding of the Intangible Cultural Heritage has incorporated

*Urtiin Duu: traditional folk long song*

in the Representative List of the Intangible Cultural Heritage of Humanity upon the proposal of Mongolia and China

*Incorporation in this List contributes to ensuring better visibility of the intangible cultural heritage and awareness of its significance, and to encouraging dialogue which respects cultural diversity*

Date
*4 November 2008*

Director-General of UNESCO

Монгол ардын уртын дуу [Photograph]. (2018). https://orkhonvalley.gov.mn/Ich/2

# Монголчуудын дуу, хөгжим
# Mongolian song, music

## Монголчуудын биет бус соёлын өвүүд
Intangible cultural heritage of Mongolians



Бурмаа, Б. (2022, June 9). Юнескод бүртгэгдсэн Монголын соёлын биет бус өвүүд [Photograph]. https://eguur.mn/333847/

***Дасгал 3. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.***
***Exercise 3. Discuss about following questions and review your understanding***

1. Морин хуур гэж ямар хөгжмийн зэмсэг вэ? Тодорхойлно уу.
2. Морин хуур үүссэн тухай домгууд ямар утга агуулгатай вэ?
3. Морин хуурын гарал үүслийн талаар судлаачид юу гэж үздэг вэ?
4. Эрт үед морин хуурыг юугаар хийдэг байсан бэ?
5. Монголчууд цагаан сараар яагаад гэртээ морин хуур тоглодог вэ?

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 108)

***Дасгал 3. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.***
***Exercise 3. Discuss about following questions and review your understanding***

1. Төрийн ёслолын өргөөнд хэзээ, яагаад “Төрийн их хан хуур”-ыг эгшиглүүлдэг вэ?
2. 2003, 2008 онд морин хуууртай холбоотой ямар үйл явдал болсон бэ?
3. Уртын дуу хэзээ үүссэн бэ?
4. Уртын дууг яагаад уртын дуу гэж нэрлэсэн бэ? Ямар онцлогтой вэ?
5. 2003, 2008 онд уртын дуутай холбоотой ямар үйл явдал болсон бэ?

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 108)

# Монголчуудын дуу, хөгжим
# Mongolian song, music

***Дасгал 4. Ардын хөгжмийн зэмсгүүдийг зөв болгож нэрлэнэ үү.***

***Exercise 4. Please correctly name the folk musical instruments.***

А. Лимбэ

Б. Ятга

В. Ёочин

Г. Морин хуур

Д. Шанз /шударга/

Е. Хуучир



Монголын радио. (2022, April 14). Лимбэ [Photograph]. www.mnb.mn. https://www.mnb.mn/i/261921



Kloisiie. (2009, June 13). Ёочин [Photograph]. Wikipedia. https://mn.wikipedia.org/wiki/%D0%81%D0%BE%D1%87%D0%B8%D0%BD#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Yangqin1.jpg



Shadowmaster2503. (2009, October 1). Ятга [Photograph]. Wikipedia. https://mn.wikipedia.org/wiki/%D0%AF%D1%82%D0%B3%D0%B0#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Mongolian_yatga_front_view.JPG



Chanzy performance [Photograph]. (2013, December 4). Wikipedia.\

https://mn.wikipedia.org/wiki/%D0%A8%D1%83%D0%B4%D1%80%D0%B0%D0%B3%D0%B0#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Chanzy_performance.jpg



Brücke-Osteuropa. (2009, August 20). Морин хуур [Photograph]. Wikipedia.

https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D1%80%D0%B8%D0%BD_%D1%85%D1%83%D1%83%D1%80#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Mongolian_horse_violin.JPG



Гэрэлт-Од, Б. (2021, February 8). Хуучир [Photograph]. montsame.mn. https://montsame.mn/mn/read/252805

## Гэрийн даалгавар 1
## Homework 1

### Мэдлэг шалгах тест - Test

1. **Монголчуудын найр наадмыг хөгжөөдөг гол зүйлс нь ................ ................., уртын дуу юм.**

   А. Төгөлдөр хуур Б. Их хуур В. Морин хуур Г. Аман хуур

2. **Морин хуур нь морин толгойтой, ......................чавхдастай хөгжмийн зэмсэг.**

   А. Хос Б. Гурван В. Дөрвөн Г. Таван

3. **Монголчууд морин хуурын ................. ..................талаар олон үлгэр домог хэлэлцсээр ирсэн.**

   А. Гарал үүслийн Б. Хөгжил дэвшлийн В. Өөрчлөлт шинэчлэлийн Г. ая эгшгийн

4. **Морин хуурыг эрт үед мөн адууны хялгасаар хийсэн .................хөрөөдөн тоглодог байжээ.**

   А. Дээсээр Б. Нумаар В. бариулаар Г. цохиураар

5. **Монголын эзэнт гүрнийг байгуулсан эзэн Чингис хааны үед .................. ................., хүндэтгэлийн найр цэнгээнийг морин хуур хөгжмөөр эхлүүлдэг байжээ.**

   А. Эмэгтэйчүүдийн баяр Б. Цэргийн баяр В. Хүүхдийн баяр Г. төрийн ёслол

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 112)

## Гэрийн даалгавар 1
## Homework 1

**6. ................ .................хэлэх, үлгэр тууль хайлахад ч морин хуур чухал үүрэгтэй.**

А. Ерөөл магтаал Б. Оньсого таавар В. Түргэн хэллэг Г. Зүйр үг

**7. Монголчууд морин хуурыг гэрийнхээ хамгийн ................ ................тавьдаг.**

А. Баруун талд Б. Зүүн талд В. Хүндтэй байранд Г. Хүнгүй газарт

**8. Уртын дууг 2000-гаад жилийн өмнө Монгол нутагт хүчирхэгчсэн Хүннү гүрний хаан..............холбоотой үүссэн гэж үздэг.**

А. Модун Шаньютай Б. Түмэн Шаньютай В. Чингис хаантай Г. Богд хаантай

**9. Уртын дуу нь ард түмний амьдрал дундаас урган гарсан утга агуулгатай бөгөөд..................байдаггүй.**

А. Шүлэг Б. Үзэгч В. Зохиогч Г. Дуучин

**10. Судлаачид ...............гаруй уртын дуу байдгаас 60 орчим дууг байнга дуулж байна гэж үздэг.**

А. 5000 Б. 6000 В. 7000 Г. 8000

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 112)

## Гэрийн даалгавар 2
## Homework  2



https://thenounproject.com/icon/homework-3841940/

- ***Сэдэвт гарсан шинэ үг хэллэгүүдийг цээжлээрэй.***

*Memorize vocabulary in the given topic*

- ***Өөрийн орны үндэсний дуу, хөгжмийн талаар бичээрэй.***

*Write about the nationality song and, music your country*

# НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES


Мөнхцэцэг, Г., Орхон,Б. (2021). Монгол орон судлал. Улаанбаатар: Линограф ХХК.

Өглөө.мн. (2015, June 9). Морин хуур үүссэн домог [Photograph].

https://www.ugluu.mn/129471.html

Munkhzaya, E. (2019, July 15). *Morin khuur structure* [Photograph]. Wikipedia.\

https://mn.wikipedia.org/w/index.php?title=%D0%9C%D0%BE%D1%80%D0%B8%D0%BD_%D1%85%D1%83%D1%83%D1%80&oldid=729109.#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:%D0%9C%D0%BE%D1%80%D0%B8%D0%BD_%D1%85%D1%83%D1%83%D1%80%D1%8B%D0%BD_%D0%B1%D2%AF%D1%82%D1%8D%D1%86.png

Johanna, K. (2007, July 23). *Икил* [Photograph]. Wikipedia.

https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D1%80%D0%B8%D0%BD_%D1%85%D1%83%D1%83%D1%80#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Igil_made_by_Oktober_Saya_side_view.gif

Хулан, Э. (2020, October 20). *Монголын металл хамтлаг* [Photograph].

https://sonin.mn/news/enews/115482

Mendee. (2011, December 3). *Norovbanzad* [Photograph]. Wikipedia.

https://mn.wikipedia.org/w/index.php?title=%D0%9D%D0%B0%D0%BC%D0%B6%D0%B8%D0%BB%D1%8B%D0%BD_%D0%9D%D0%BE%D1%80%D0%BE%D0%B2%D0%B1%D0%B0%D0%BD%D0%B7%D0%B0%D0%B4&oldid=685024.#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Norovbanzad.jpg

# НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES


Бадрал, С. (2016, September 12). Уртын дуучид [Photograph].

https://ikon.mn/n/tsw

Бурмаа, Б. (2022, June 9). Юнескод бүртгэгдсэн Монголын соёлын биет бус өвүүд [Photograph].

https://eguur.mn/333847/

Монголын радио. (2022, April 14). Лимбэ [Photograph]. www.mnb.mn.

https://www.mnb.mn/i/261921

Kloisiie. (2009, June 13). Ёочин [Photograph]. Wikipedia.

https://mn.wikipedia.org/wiki/%D0%81%D0%BE%D1%87%D0%B8%D0%BD#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Yangqin1.jpg

Shadowmaster2503. (2009, October 1). Ятга [Photograph]. Wikipedia.

https://mn.wikipedia.org/wiki/%D0%AF%D1%82%D0%B3%D0%B0#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Mongolian_yatga_front_view.JPG

Chanzy performance [Photograph]. (2013, December 4). Wikipedia.\

https://mn.wikipedia.org/wiki/%D0%A8%D1%83%D0%B4%D1%80%D0%B0%D0%B3%D0%B0#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Chanzy_performance.jpg

Brücke-Osteuropa. (2009, August 20). Морин хуур [Photograph]. Wikipedia.

https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D1%80%D0%B8%D0%BD_%D1%85%D1%83%D1%83%D1%80#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Mongolian_horse_violin.JPG

Гэрэлт-Од, Б. (2021, February 8). Хуучир [Photograph]. montsame.mn.

https://montsame.mn/mn/read/252805

## Монголчуудын дуу, хөгжим
## Mongolian song, music

**Анхаарал хандуулсанд баярлалаа.**
**Дараагийн хичээл хүртэл баяртай!**



https://www.flaticon.com/free-icon/teacher_1995413



https://thenounproject.com/icon/lecture-1525984/